

НАГ, Х№-1, Д-1, ХН-117

УЛААНБААТАР ХОТЫН ЗАХИРГААНЫ ГАЗРЫН САНХҮҮГИЙН ТҮР ЭРХЛЭХ ДҮРЭМ

НЭГ, ХОТЫН САНХҮҮГИЙН ТУХАЙН ТҮР ДҮРЭМ

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. Нийтийн дүрэм

НЭГДҮГЭЭР ЗҮЙЛ. Хотын харьяат аж ахуйн явдлыг сайжруулах тухай, улсын орлого зарлагаас онц болгон захиргааны газраас орлого зарлагын данс төсөвлөж гүйцэтгэвээс зохимуй.

ХОЁРДУГААР ЗҮЙЛ. Хотын орлого зарлагын данс оруулах татварыг тодорхойлох нь: Нэг, ардын засгийн газрын тогтоолын ёсоор хотын захиргаанд шилжүүлэн өгсөн элдэв татвар ба ашиг улсын татвар дээр хувь нэмэгдүүлэх бас хотын захиргаанаа бүхий ашгийг хүсэж байгуулсан газрын хөрөнгийн ашиг басхүү тус хотын захиргааны газраа хурааваас зохих элдэв татвар болмуй. Хоёр, энэхүү дүрмийн ёсоор хотын захиргааны газар ноогдсон зарлага ба мөнхүү дүрэмд үл тодорхойлсон бөгөөд хотын захиргаа хурааваас зохих бусад зарлага болмуй. Гурав, эл хотын санхүүг тус хотын захиргааны газраас эрхэлж, зохих газруудаар уламжлан гүйцэтгэмүй. Дөрөв, Ар Монгол улсын ардын засгийн сангийн явдлын яамнаас эрхлэн гүйцэтгэвээс зохих явдлыг тодорхойлох нь: Нэг, Хотын санхүүгийн явдлыг хянан харгалзах ба эрхлэх. Хоёр, хотын санхүүгийн тухай зүй зохисыг үзэж, дүрэм заавар зохиох. Гурав, зүй зохисыг үзэж бичиг албын явдал ба данс тайланг хянан байцааж заах. Дөрөв, бусад албын газрууд лугаа харилцаж хотын захиргааны газраас энэхүү дүрэмд үл тодорхойлсон шинэ татварыг хураах ба хотын санхүүгийн зэрэг орлого зарлагын тухай мэдүүлсэн данс хуудас бичгүүд хянан тогтоож, улмаар засгийн газраа явуулж, гүйцэтгэн тогтоолговоос зохимуй. Тав, энэхүү дүрэмд үл оруулсан элдэв татварын дүрэм зохиох. Зургаа, санхүүгийн хэргийг хэрхэн эрхэлж байсныг албан ёсоор буюу мэдүүлснийг баримтлан байцааж, мөн санхүүгийн тухай гаргасан тогтоол тушаалыг хянан үзэж хэрвээ хууль дүрэмд үл нийлэлцэх зүйл буй аваас засгийн газраа явуулж өөр болгон тогтоолговоос зохимуй.

ТАВДУГААР ЗҮЙЛ. Хотын төлөөлөгчдийн хурлын эрхэлбээс зохих явдлуудыг тодорхойлох нь: Нэг, хотын санхүүгийн тухай явдлыг тус захиргааны газраас хэрхэн эрхлэх улсын дүрэмд таацуулан нийлүүлцэхээр шахан тогтоох. Хоёр, энэхүү дүрмийн ёсоор хотын санхүүд хурааваас зохих элдэв татвар төсөвлөснийг батлах. Гурав, хотын орлого зарлагыг төсөвлөсөн данс ба тайланг хянан хэлэлцэж батлах. Дөрөв, Энэхүү дүрэмд үл дурдсан бөгөөд хэрвээ шинэ татвар хураах аваас тухайг сангийн явдлын яамнаа уламжлан засгийн газраа батлуулах. Тав, хэрвээ хотын газраа гачигдалтай зүйл тохиолдвоос сангийн яамнаа уламжлан засгийн газраа улсын сангаас мөнгө олгуулахыг мэдүүлэх. Зургаа, бусад хүнээс зээл болгон мөнгө авах явдлыг батлах ба юм бариулан авах явдлыг эрхэлмүй.

ЗУРГААДУГААР ЗҮЙЛ. Хотын захиргааны эрхэлбээс зохих явдлыг тодорхойлох нь: Нэг, тус хотын орчим дотор сангийн яамнаас заан тушаасан ёсоор санхүүгийн явдлыг эрхлэх.

Хоёр, энэхүү дүрэмд нийлүүлэн орлого зарлагын төсөвлөсөн данс зохиож төлөөлөгчдийн хуралд шилжүүлэн батлуулахууд бэлтгэх. Гурав, хотын орлого зарлагыг төлөөлөгчдийн хурлаар баталсныг дагаж гүйцэтгэх ба тухай тайланг мөн хуралд шилжүүлэн гүйцэтгэсэн шийтгүүлэхууд бэлтгэсүгэй. Дөрөв, хотын алба татварыг хичнээн хугацааны дотор яахан хурааж дуусгах явдлыг тогтоох. Тав, хотын элдэв татварыг үнэн шударгаар хураах явдлыг эрхлэх.

Зургаа хотын элдэв татварыг хувааж төлөх, тогтсон цагийг хойшлуулах татварыг хэтрүүлэх, эгүүлэн өгөх тухайн явдлыг гүйцэтгэн шийтгэвээс зохимуй.

ХОЁРДУГААР БҮЛЭГ. Хотын газраа ямар хэрэг явдалд мөнгө зарцуулбаас зохих тухай

ДОЛООДУГААР ЗҮЙЛ. Хотын газрын бүх зарлагыг тодорхойлох нь:

1. Хотын захиргааны ба харьяат олон алба тамгын газраа
2. Хотын аж ахуйн явдал
3. Гэгээрүүлэх явдал
4. Өвчнөөс хамгаалах явдал
5. Үгээгүү ядуу нарыг тэтгэх явдал
6. Аж үйлдвэрийн явдал эдгээр болой.

НАЙМДУГААР ЗҮЙЛ. Хотын захиргаа ба харьяат олон албын газрын зарлагыг тодорхойлох нь:

1. Хотын захиргааны газрын албан хаагчдын цалин хэрэглэл
2. Хотын захиргааны хэлтсүүд ба тус хотын цагдан сэргийлэх хорооны албан хаагчдын цалин хэрэглэл
3. Хотын захиргааны аж ахуйн явдал ба бичиг албын газрын зарлага болмуй.

ЕСДҮГЭЭР ЗҮЙЛ. Хотын аж ахуйн явдлын зарлагын зүйлийг тодорхойлох нь:

1. Хотын захиргаа бүхий байшингуудын дурсгал болгон байгуулсан фимиуник \гаргацгүй үг\ зэргийг засах ба шинэ байгуулах зүйл
2. Хотын байдлыг сайжруулах зүйл
3. Хотын дотор эмнэлгийн явдлыг сайжруулах зүйл

4. Хотыг галын аюулаас хамгаалах зүйл
5. Гудамж цэвэрлэх гүүр зэргийг засах хотын тодор явах зам тэргээр буюу уурын хүчээр явах тэрэг бэлтгэх зүйл
6. Зах зээлийн ба дэлгүүр байгуулах зүйл
7. Хотын зах зээлийн газраа олон ардад хэрэгсүүлэхээр жин тэгнүүр байгуулах зүйл
8. Ломбард байгуулах ба тус газар хэрэгсүүлэх зүйл
9. Хотын газрыг хуваах эрхлэх зүйл болмуй.

АРАВДУГААР ЗҮЙЛ. Гэгээрүүлэх явдлын тухай зарлагыг тодорхойлох нь:

1. Улсын сангаар байгуулсан номын сургуулиас өөр хотын газраа байгуулсан сургуулийн багш нарын цалин хэрэглэл
2. Улсын сангаас багш нарын цалин хэрэглэлийг олгож байсан боловч тус сургуулийг ба бусад хотын газраас байгуулсан сургууль нарын аж явдал бэх цаас зэрэг зүйл, албан хаагчдын цалин хэрэглэл олговоос зохимуй.
3. Өнчин ядуусыг тэтгэх байшин байгуулах бусад олон зүйлийг бэлтгэх ба басхүү хүүхдийн цэнгэлдэх газар зэргийг байгуулах ба эл газруудын бүгд зарлага
4. Хотын аж ахуйн явдалд боловсруулахаар түр байгуулах сургуулийн зарлага
5. Хотын газраа цахилгаан сүүдэр зэрэг тусгалын хүрээлэн байгуулах ба мөн газрын бүгд зарлага.
6. Хотын газраа ном ба сонин зэргийг үзэх хоорондоо харилцан үзэх өгүүлэлдэх сургаал хэлэх зэргийн газар байгуулахын зарлага.
7. Хотын газраа байгуулсан цэнгэлдэх хүрээлэнгийн газрын бүгд зарлага. Өөр улсын сангаас байгуулсан энэ мэтийн газар үл ормуй.

АРВАН НЭГДҮГЭЭР ЗҮЙЛ. Ардын өвчнөөс хамгаалах газрын тухай зарлагыг тодорхойлох нь: Хотын эмнэлгийн газрууд хэмээвээс өвчтөнийг үзэх хэвтүүлэх зэргийн газрыг байгуулах ба эл газруудын аж ахуйн ба тэнхимийн зарлага.

2. Хотын ариун цэврээр байгуулахыг эрхлэх тухай зарлага
3. Халдвартай хижиг өвчнийг устгах тухай улсын сангаас өөр байгуулсан газрын зарлага.

АРВАНХОЁРДУГААР ЗҮЙЛ. Үгээгүү ядуу ардыг тэтгэх газрын зарлагыг тодорхойлох нь:

1. Ажлын хүчин хийсэн ардын суух байшин ба үйлдвэрийн газар байгуулах бөгөөд мөн газруудын зарлага
2. Гуйланчин нарын зүй зохисыг үзэж журамлан эрхлэх тухай зарлага
3. Хотын захиргааны газар буюу засгийн газраас ажлын хүч хангагчдын тусгай үүрдийн мөнгөн тэтгэмж олгуулахын тухай зарлага

АРВАН ГУРАВДУГААР ЗҮЙЛ. Хотын аж үйлдвэрийн тухай зарлагыг тодорхойлох нь:

1. Хотын малыг нядлах, цахилгаан гэрэл машинаа хэрэгсүүлсэн худаг телефон утас элдэв юм үйлдэх газар зэргийг байгуулах ба сэлбэн гүйцэтгэх тухайн бүгд зарлага болмуй.

ГУРАВДУГААР БҮЛЭГ. Хотын орлогын тухай

АРВАН ДӨРӨВДҮГЭЭР ЗҮЙЛ. Хотын захиргааны газраас төсөвлөж, хураах элдэв зүйлийн татварыг тодорхойлох нь:

1. Тус хотын орчим дотор бүхий хашаа байшингаас хураах
2. Хотын орчим дотор бүхий газраас хураах
3. Ашгийг бодож тарьсан ногоо зэргээс хураах
4. Агт морь, гүү ба дөрвөн дугуйт хөнгөн тэргээс хураах
5. Унах дугуй ба уурын тэргүүдээс хураах
6. Ашгийг бодож хүн зэргийг тээн зөөх явдлыг эрхлэгчдээс хураах
7. Хотын газраа тээн авчирсан ба тээн гаргасан зүйлээс хураах
8. Ардын цэнгэлдэх газраас хураах
9. Хотын газар буй хашаа байшинг хувааж бусдад шилжүүлэх ба акт хэмээх бичиг ба шинэ хашаа байгуулах тухайгаас хураах
10. Хотын зах зээлийн газраа худалдан авагчдаас хураах
11. Хотын газар худалдахаар авчирсан малаас хураах
12. Үнэмлэх хуудсуудыг бүртгэхэд хурааваас зохимуй.

АРВАН ТАВДУГААР ЗҮЙЛ. Хотын орчим дотор бүхий хашаа байшинд татвар ноогдуулах бөгөөд эл татварыг тийнхүү хашаа байшинд сууж буюу эзэн болж буй хүнээс хураамуй. Хэрвээ сууж буй ба ажил болох хүнгүй аваас уул эзнээс хураамуй.

АРВАН ЗУРГААДУГААР ЗҮЙЛ. Татвараас хэлтрүүлэх хашаа байшингуудыг тодорхойлох нь:

1. Улсын сангийн хөрөнгө болох бөгөөд ардын цэрэг сууж буй улсын орлого зарлагын төсөвлөсөн дансанд оруулсан яам ба алба тамгын газрын орон байшин сургуулийн байшин эмнэлгийн байшингууд
2. Хоёр жилийн хугацаагаар байгуулсан суух газар
3. Татвар хураах үнэд гүйцэхгүй орон байшин ба эсгий гэр эдгээр болой.

АРВАН ДОЛООДУГААР ЗҮЙЛ. Хашаа байшинг тусгай комиссоор үнийг тогтоолгож дараа хотын захиргааны газраас хичнээн мөнгө хураах ба хичнээн хугацааны дотор төлж, дуусгахыг тогтоовоос зохимуй. Үүнд тодорхойлох нь: Хашаа байшингийн үнээс татварыг нэгэн зуун хувиас нэгэн хувь хагасаас хэтрүүлж үл болох боловч хотын захиргааны газраас орон байшингийн үнийг зэргээр ялган хувиарлаж, тухай бүрт татварыг таацуулан тогтоож, болмуй.

АРВАН НАЙМДУГААР ЗҮЙЛ. Хотын орчим дотор бөгөөд үргэлж олгосон буюу түрээслэн авсан ба зүйлийн учраа олгосон газар дээр ашгийг бодож ногоо тарих аваас тухайгаас татвар хурааваас зохимуй.

АРВАН ЕСДҮГЭЭР ЗҮЙЛ. Агт морь гүү ба дөрвөн дугуйнаас татвар хураахыг тодорхойлох нь хотын усан гүүр ба ашгийг бодож хүн зэргийг тээн зөөх явдлыг эрхлэгчдийн гүү морьд ба тэргүүдээс бусад энгийн хүмүүс, газар, засгийн олон албан газраа ба албан хаагчдын хэрэгсэж бүхий агт морь, гүү ба гурван дугуйтай тэргүүдээс хураах бөгөөд жич төлийг сайжруулахаар байгуулсан газрын адуунаас үл хураамуй. Үүнд тодорхойлох нь: Хүнд ажлын гүү, морьдоос хөнгөн явах гүү, моринд ногсон /ноогдсон/ татварын нэгэн зуун хувийн хорин таван хувиас хэтрүүлэн хурааж үл болмуй.

ХОРЬДУГААР ЗҮЙЛ. Татвар хураах унах дугуй ба уурын тэргүүдийг тодорхойлох нь засгийн олон албан газраа албан хаагчид ба энгийн газрын хүмүүсүүд хэрэгсэж бүхий унах дугуй ба уурын тэргүүдээс гадна хотын дотор хүн зэргийг зөөх дугуй ба тэргүүд нэгэн адил ормуй.

ХОРИН НЭГДҮГЭЭР ЗҮЙЛ. Хотын газар ашгийг бодож өөрсдийн хувийн гүү морьд зэргээр хүн зэргийг тээн зөөх газраа хүмүүсээс татвар хураах ба бас нэгэн адил эл явдалд өөрийн гүү морьд зэргийг бусдад хөлсөөр өгөгчдөөс хурааваас зохимуй.

ХОРИН ХОЁРДУГААР ЗҮЙЛ. Хотын газраа тээн авчирсан ба тээн гаргасан юмнаас татвар хураах болбоос эл татвараас хэлтрүүлэхийг нь тодорхойлбоос

1. Хотыг нэвтрэн улмаар явах жин
2. Эзрэгийн \гаргацгүй үг\ ачаа
3. Хэргийн хүмүүсийн ачаа
4. Засгийн олон албан газруудын ачаа
5. Гурван пүүнээс илүүгүй биеийн дэргэд авч явсан юм.
6. Хөдөө сууж бүхий ардын өөрийн хүү аж ахуйн явдлаас боловсруулан гаргасан юм болой.

Үүнд тодорхойлох нь: Хотын захиргааны газраас тээн авчирсан буюу тээн гаргасан юмны үнэ ба хэмжээнд таацуулан пүүнд буюу хэсгээр ялган зохиож тухай бүрээс хураах, багтаах зэрэгтэй болмуй. Хоёр эл татварыг гаалийн түрээс лугаа нэгэн удаа гаалийн түшмэл буюу хотын захиргааны газраас тусгай томилогдсон албаны түшмэл хурааваас зохимуй.

ХОРИН ГУРАВДУГААР ЗҮЙЛ. Сургуулийн сургагч нар цэргүүд, өнчид хэрэгтний тус тусад сургууль цэргийн хороо, өнчин тэтгэврийн байшин гяндны газраа гаргах бүжиг наадмаас бусад цэнгэлдэх хүрээлэнгийн газраа үзүүлэхээр олгож, пиуд татвар нэмж хурааваас зохимуй.

Үүнд тодорхойлох нь: Эл нэмж хураах татварыг бүжиг наадам эрхлэгч пиу бичгийн үнэ хураах лугаа нэгэн адил хотын захиргааны газраас тогтоосон хугацааны дотор хураасан эл татварыг цөм авчирч, хотын захиргааны газраа дүрмийн ёсоор хурааваас зохимуй.

ХОРИН ДӨРӨВДҮГЭЭР ЗҮЙЛ. Шүүх таслах газрын шийдвэрийн ёсоор худалдсан юмны үнээс нэгэн зуун хувийн таван хувийг татвар болгон хурааваас зохимуй.

ХОРИН ТАВДУГААР ЗҮЙЛ. Орон байшин бусдад хуваан шилжүүлэх буюу орон байшин байгуулахаар хэлэлцэж акт хэмээх бичиг тогтоох ба орон байшин байгуулахаар эрх олгосон явдал буй аваас худалдсан буюу тусгай үлсэн мөнгөний нэгэн зуун хувийн гурван хувийг бодож татвар хурааваас зохимуй.

ХОРИН ЗУРГААДУГААР ЗҮЙЛ. Хотын зах зээлийн газраа пиу бичиггүйгээр худалдан явагчдаас татвар хураах боловч өөрийн хувийн хөрөнгө болох хуучин эд буюу басхүү өөрсдийн аж ахуйн явдлаас боловсруулан гаргасан мах, тос, ноос, арьс зэргээс татвар хурааж үл болмуй.

Үүнд тэмдэглэх нь: Хотын захиргааны газраас хичнээн татвар хураах тогтоох эрхтэй боловч тэргэнд тээн явж худалдаачдаас нэгэн жилийн хугацаагаар дугаар зэргийн худалдааны пиу олгоход хураах мөнгөний зуун хувийн хувиас хэтрүүлж үл болох ба бас биедээ үүрч худалдаачдаас нэгэн жилийн хугацаагаар дугаар зэргийн худалдааны пиут хураах мөнгөний зуун хувийн хувиас хэтрүүлж үл болмуй.

ХОРИН ДОЛООДУГААР ЗҮЙЛ. Хотын зах зээлийн газраа худалдахаар авчирсан үхэр зэргийн том мал ба хонь зэргийн жижиг малаас тус бүр татвар хурааваас зохимуй.

Үүнд тодорхойлох нь: Эл татварыг хотын нядлах газраа нядалсны хөлсийн нэгэн хамт хураамуй.

ХОРИН НАЙМДУГААР ЗҮЙЛ. Үнэмлэх хуудас бичгүүдийг бүртгэж тухайд татвар хураах явдлыг хотын цагдан сэргийлэх хорооноос эрхлэн гүйцэтгэвээс зохимуй.

Үүнд тодорхойлох нь: Эл бүртгэх явдалд онц болгон тусгай хуудас бэлтгэхэд зарцуулсан мөнгөний тоог таацуулан хурааваас зохимуй.

ХОРИН ЕСДҮГЭЭР ЗҮЙЛ. Хотын хөрөнгө болох орлогыг тодорхойлох нь:

1. Хотын хөрөнгөөр байгуулсан алба тамгын ба бусад газрын орлого
2. Хотын захиргааны газарт шилжүүлэн өгсөн буюу тус газрын хөрөнгө зэргийг бусдад түрээслэн өгсний орлого
3. Хотын бусад хөрөнгө ба ашгийг бодож эрхэлсэн зүйлийн орлого
4. Хотын хөрөнгө болох бөгөөд засгийн олон албаны газрын захиргаанаа орж ашиглан бүхий орлогоос хотын захиргааны газраа эгүүлэн өгөх хүртэл хувь гаргаж олгох ашгийн хамт эдгээр зүйлүүд болмуй.

ГУЧДУГААР ЗҮЙЛ. Энэхүү дүрэмд дурдсан татвараас гадна хотын орлого болгохоор хотын захиргааны газраас сангийн яамнаа уламжлан худалдааны ба хоолны зэрэг газруудад олговоос зохих пиу бичгийн үнэ дээр мөн үнийн зуун хувийн арван хувиас илүүгүй нэмж хураах явдлыг тогтоон эрхэлбээс зохимуй.

ГУЧИН НЭГДҮГЭЭР ЗҮЙЛ. Монгол улсад суугаа улсын төлөөлөгчийн газар ба төлөөлөгчийн биеийг хотын элдэв татвараас хэлтрүүлбээс зохимуй. Нэгдүгээр бүлэг. Хотын элдэв татварын дүрэм зохиох ба хураах тухай

ГУЧИН ХОЁРДУГААР ЗҮЙЛ. Хотын захиргааны газраа татварын дүрэм гаргахын учраа хэрэг явдлыг бэлтгэж гүйцэтгэсний дараа эл татварын дүрэм дуусгах хороо болзооноос нэгэн сарын урьд төлбөөс зохигчдод зарлан сонсговоос зохимуй.

ГУЧИН ГУРАВДУГААР ЗҮЙЛ. Хэрвээ эл татварыг тогтоосон болзооны дотор төлж үл дуусгах аваас хотын захиргааны газраас дутуу болох мөнгөний зуун хувийн нэгэн хувиас хэтрүүлэхгүй хугацаа дууссан өдрөөс эхлэн хүүг өдөр тутам нэмэх эрхтэй болмуй.

ГУЧИН ДӨРӨВДҮГЭЭР ЗҮЙЛ. Хугацааны дотор төлж үл дууссан татварыг хүүгийн хамт татгалзах зүйлгүй нэхэмжилбээс зохимуй.

ГУЧИН ТАВДУГААР ЗҮЙЛ. Хэрвээ эл татварыг төлж чадахгүйгээр гачигдал хүмүүс буй ахун тухайг мэдэгдэх аваас хотын захиргааны газраас тухайг хянаж үзээд нэгэн жилийн хугацааны дотор төлөхөөр урьд тогтсон хугацааг өөрчилж болохоос гадна эл татвараас бүрмөсөн хэлтрүүлэх эрхтэй болмуй.

ТАВДУГААР БҮЛЭГ. Хотын орлого зарлагын төсөвлөсөн данс зохиох ба батлахын тухай

ГУЧИН ЗУРГААДУГААР ЗҮЙЛ. Хотын орлого зарлагын төсөвлөсөн дансны ёсоор мөнгийг зарцуулах бөгөөд хэрвээ төлөөлөгчдийн хурал буюу хотын захиргааны газраас орлого зарлагын төсөвлөсөн данснаас өөр зүйлд мөнгийг зарцуулах аваас тухайг нэгэн жилийн хугацаагаар төсөвлөсөн дансны ёсоор мөнгийг бодож зээл болгон авах буюу нөхөн төсөвлөвөөс зохимуй.

ГУЧИН ДОЛООДУГААР ЗҮЙЛ. Орлого зарлагын төсөвлөсөн дансыг татвар хураах жилээс нэг сарын урьд зохиож дуусгамуй.

ГУЧИН НАЙМДУГААР ЗҮЙЛ. Орлого зарлагын төсөвлөсөн дансыг анх төсөвлөхүйд эсэргүүн жилийн татвар хөрөнгө ба бусад ашгийг хүсэж байгуулсан газруудын орлого басхүү улсын татвараас хувь олгох ба эл татварт нэмэгдүүлэх зэргийг сайн бодож орлогыг төсөвлөвөөс зохимуй.

ГУЧИН ЕСДҮГЭЭР ЗҮЙЛ. Орлого зарлагын төсөвлөсний дараа зарлагыг зүй зохисыг үзэж төсөвлөх бөгөөд хэрвээ чухал бус зарлага буй аваас дүрмийн дээр дурдсан зарлагыг орлогын мөнгөнд таацуулан оруулахад үйлдэх бөгөөс нэгэн адил оруулж болмуй.

ДӨЧДҮГЭЭР ЗҮЙЛ. Орлого зарлагын төсөвлөсөн данс зохиохууд баримт болгон итгүүлэх явдлыг тодорхойлон гаргах ба мөнхүү дансанд үлэмжхэн ашиг тустай зүйлийг тодорхойлбоос зохимуй.

ЗУРГААДУГААР БҮЛЭГ. Хотын төсөвлөсөн дансны ёсоор эрхлэн гүйцэтгэж, тайлан данс зохиох тухай

ДӨЧИН НЭГДҮГЭЭР ЗҮЙЛ. Хотын орлого зарлагын төсөвлөсөн дансыг батласны дараа хотын захиргаанаас тушаасныг дагаж, мөнгөн сангийн хэлтсүүдээс эл дансны ёсоор зарцуулахын учир зохих хэлтсүүдэд мөнгө урьд болгон олговоос зохимуй.

ДӨЧИН НЭГДҮГЭЭР ЗҮЙЛ. Төсөвлөсөн дансны ёсоор урьд болгон олгосон мөнгийг харьяат хэлтсүүдээс төсөвлөсөн ёсоор зарцуулахаас гадна эл данс батлуулахад үл мэдсэн бусад зүйлд зарцуулж үл болмуй.

ДӨЧИН ХОЁРДУГААР ЗҮЙЛ. Төсөвлөсөн жилийн дууссаны дараа хэрвээ урьд болгон авсан мөнгө нь үлэх аваас зарцуулах явдлыг устгах ба басхүү урьд болгон өгөх явдал нэгэн адил устгаж орлого зарлагын явдлыг тодорхойлбоос зохимуй.

ДӨЧИН ДӨРӨВДҮГЭЭР ЗҮЙЛ. Төсөвлөсөн жилийн дуусмагц дараа орлого зарлагын тайлан зохиох бөгөөд эл тайланд тодорхойлох нь: Нэг, гүйцэтгэтүгэй. Зарлага. Хоёр, хугацааны дотор төлөөгүй татвар ба өр зээлийг тодорхойлох боловч чухамхүү хураахад төлж чадах эсэхийг басхүү тодорхойлох. Эсэргүүн жилийн орлогоос төлөхөөр зарцуулсан явдал. Дөрөв, төсөвлөсөн жилд хураасан орлогыг тодорхойлмуй.

ДӨЧИН ТАВДУГААР ЗҮЙЛ. Төсөвлөсөн дансны хугацаа дуусмагц тайлан зохиож төлөөлөгчдийн хуралд хэлэлцэж баталсны дараа сангийн явдлын яамнаа үлэмжхэн явуулж, үнэн нь байцаан үзүүлэхээс гадна хотын санхүүгийн явдлыг шалган байцаахад бэлтгэвээс зохимуй.

Бүгд Найрамдах Монгол Ард Улсын арван тавдугаарын 2 сарын 23